

НИЙСЛЭЛИЙН ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВ

ИЛТГЭХ ХУУДАС №4

Төв аймгийн Архуст, Баянжаргалан сумын нутагт хийсэн тарваган тахал түүнтэй хам тохиолдох өвчний байгалийн голомт хяналтын тандалт, хайгуул шинжилгээ

2024 оны 07 дугаар сарын 10

Багануур дүүрэг

Нэг. Үндэслэл:

Төв аймгийн Архуст, Баянжаргалан сум нь зүүн, зүүн хойд талаараа Мөнгөн-Хэрлэнгийн цурав голомтод хамаарах Гурван байдлагийн өр голомттой баруун ба баруун хойд хэсгээрээ Туулын цурав голомттой хамрагдах Богдхан уулын өр голомттой хил залгаа оршдог. Төв аймгийн Архуст суманд 1992, 1993, 1994, 1996 онуудад тарваган тахлын эерэг материал илэрч байсан.

Мэрэгчдээс үлийн цагаан оготно, шар чичүүл, дагуурын огдой, хэрэлзгий оготно, монгол тарвага, урт сүүлт зурам, махчин шувуудаас бүргэд, тас, сар, шонхор, харцага, араатан махчин амьтдаас хотны үен, өмхий хүрэн, үнэг, хярс, саарал чоно зэрэг амьтад зонхилон тохиолдоно.

Хүний өвчлөл: Тус нутгаас 1992 онд хулгана тахлаар нэг хүн өвчилж, ийлдэс судлалын шинжилгээгээр тарваган тахлын эерэг хариутай материал, 1998 онд Архуст сумын Хөшөөт гэдэг газар Клебсиллаар хүн өвчилж нас барсан, 2007 онд Монгол-Хятадын судалгаа шинжилгээний төв хүрээлэнгийн баг, БГХӨСҮТөвийн /хуучнаар/ эмч мэргэжилтнүүдийн хамтарсан шинжилгээгээр урт сүүлт зурмаас тарваган тахал түүнтэй хам тохиолдох хуурмаг сүрьеэгийн эсрэгтөрөгч илрүүлсэн. Төв аймгийн Архуст, Баянжаргалан суманд 2009 оноос хойш тарваган түүнтэй хам тохиолдох өвчний байгалийн голомт хяналтын шинжилгээ хийгдээгүй байна.

Хоёр. Судалгааны арга зүй:

2.1. Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийн 2024 оны календарчилсан төлөвлөгөөний дагуу Төв аймгийн Архуст, Баянжаргалан сумын нутаг дэвсгэрийг хамруулан тарваган тахал, түүнтэй хам тохиолдох өвчний байгалийн голомт хяналтын тандалт, хайгуул, шинжилгээг ЗӨСҮТ-ийн Захирлын 2017 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/07 тушаалаар баталсан “Тарваган тахал түүнтэй хам тохиолдох халдварт өвчний байгалийн голомтын тандалт судалгааны заавар”-ыг баримтлан 2024 оны 06 дугаар сарын 26–ны өдрөөс 2024 оны 07 дугаар сарын 5–ны өдрийг дуустал Халдвар судлагч их эмч Б.Наранхүү ахлан, Амьтан судлагч Б.Учрахбаяр, Шимэгч судлагч Б.Мөнгөнбагана, Нян судлаач Б.Ганбилэг, Ариутгагч Ж.Лхамсүрэн, Хээрийн шинжилгээний жолооч М.Баярсайхан нар хамтран хийж гүйцэтгэлээ.

Гурав. Хийж гүйцэтгэсэн ажил:

3.1. Амьтан судлал:

3.1.1. Төв аймгийн Архуст, Баянжаргалан сумын 5 сектор, 45,000 га талбайд Тарваган тахал түүнтэй хам тохиолдох өвчний байгалийн голомт хяналтын тандалт, хайгуул шинжилгээг хийж гүйцэтгэсэн.

3.1.2. Судалгаагаар нийт 55 амьтан олзворлосон. Үлийн цагаан оготно /*Lasiopodomys brandtii*/ 49, Сибирь алагдаага /*Allagtaga sibirica*/ 4, дагуур зурам /*Citellius dauricus*/ 2 олзворлосон. Амьтан олзворлосон биотоп бүрд цаг уурын хэмжилт хийсэн.

3.1.3. 7 га талбайд агуулагчдын тооллого хийсэн.

3.1.4. Мэрэгчийн 350 нүх үзэж, 55 амьтан самнаж 46 бүүрэг, 446 хачиг нийт 492 гадны шимэгч цуглуулан лабораторийн шинжилгээнд хамруулахаар болов.

3.1.5. Нийтийн хайгуулыг 6 удаа хийсэн. Хайгуулаар зэм үхтэл олдоогүй, махчин шувуудын 12 гулгидас цуглуулж лабораторид өгөв.

3.1.6. Араатан амьтан болон махчин шувууны тооллого 3 удаа хийхэд хярс үнэг 2, шар үнэг 1, махчин шувуу 26 тоологдсон.

3.2. Лабораторийн шинжилгээ :

Монгол Улсын Үндэсний стандарт “Тарваган тахал өвчний оношилогоо, эмчилгээ, тандалт” MNS 5348-41:2010, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 161 дугаар тушаалаар батлагдсан “Зоонозын халдварт өвчний үед ажиллах халдвар хамгаалал, биоаюулгүй ажиллагааны дэглэмийн заавар”, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/160 дугаар тушаалаар батлагдсан зааврыг баримтлан лабораторийн шинжилгээг хийж байна.

Төв аймгийн Архуст, Баянжаргалан сумын нутаг дэвсгэрээс олзворлосон 55 ОША-с цээжний хөндийн цус, элэг, дэлүү, цавины булчирхай, уушги, зүрхнээс наац авч 275 сорьц, (ГАШ) 492, гулгидас 12 нийт 779 сорьц материал хүлээн авч НЗӨСТ-ийн лабораторид нян харах, нян судлал, шинжилгээнд хамруулан ажиллаж байна.

Зураг 1.Шинжилгээний явцаас /2024.07 сар. Архуст, Баянжаргалан сум/



Лабораторийн шинжилгээнд нийт ОША - 55, ГАШ-10 бүлгийг нян харах, нян судлал шинжилгээ үргэлжлэн хийгдэж байна.


3.3. Хүн амын тандалт судалгаа:

3.3.1. 2024 оны 06 дугаар сарын 29-ны өдрөөс 07 дугаар сарын 02-ний өдөр.

Халдвар судлагч их эмч 2024 оны 06 дугаар сарын 29-ний өдрөөс 07 дугаар сарын 01-ний хугацаанд Төв аймгийн Архуст сумын Ноён-Шанд 1-р баг, Нарст 2-р багийн малчин өрхийн 30 иргэнээс Тарваган тахлын тандалт судалгаа зааврын дагуу авч, иргэд, малчдад байгалийн голомтот, зоонозын халдварт өвчний халдварлах зам, эмнэлзүйн талаар мэдээлэл хийж, зоонозын халдварт өвчнүүдийн талаарх мэдээлэл бүхий 30 ширхэг тараах материалыг иргэдэд тарааж, ажилласан.



3.3.2. Төв аймгийн Архуст сумын Эрүүл мэндийн төвийн 15 эмч мэргэжилтэн нарт 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдөр Зоонозын халдварт өвчнүүдийн талаар сургалт мэдээлэл хийж ажиллалаа.



3.3.3. Эрүүл мэндийн төвийн дарга И.Бадамгарав, Дархлаажуулалт хариуцсан сувилагч Б.Жаргалмаа нарт ажлын удирдамж танилцуулж. Тархвар судлалын заалтаар хийгддэг зоонозын өвчний эсрэг дархлаажуулалтын үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт, зөвлөн туслах үйлчилгээ, зөвлөгөө зааварчилгаа өгч ажилласан.

Үүнд:

3.3.3.1. Галзуу өвчний эрсдэлд өртсөн тохиолдолд анхан шатны нэгж дээр анхны тусламжийг үзүүлж шархны цэгцлэлт хийж яаралтай галзуугийн эсрэг вакцинд хамруулахад сумын эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн сургалт мэргэшсэн байдал.

3.3.3.2. Галзуу өвчний эсрэг вакцины орлого, зарлага, устгал байгаа эсэх.

3.3.3.3. Дархлаажуулалтын ажлын байрны нөхцөл байдал, урсгал, тоног төхөөрөмжийн хүчин чадал, вакцин хадгалалт, хөргөгчийн хэм, паспорт хөтлөлт.



3.3.3.4. Вакцин үйлдвэрлэгчийн заавар ойлгомжтой эсэх, бусад вакцинтай андуурахаас сэргийлэх талаар.

3.3.3.5. Эрүүл мэндийн сайдын тушаалын дагуу анхан шатны маягт хөтлөлт хийгдэж байгаа байдал.

3.3.3.6. Галзуу өвчний эсрэг вакцинд хамрагдсан байдал.

3.3.3.7. Эрүүл мэндийн төвийн эмч, ажилтнууд, болон иргэдэд галзуу өвчний эрсдэл, эрсдэлд өртсөн тохиолдолд вакцин бүрэн тунгаар хийлгэхийн ач холбогдлын талаар сургалт мэдээлэл хийсэн байдал.

3.3.3.8. Мэргэжлийн ямар байгууллагаас заавар, зөвлөмж авсан талаарх мэдээллүүдийг авч ажиллалаа.





ХЯНАСАН:
ТАСГИЙН ЭРХЛЭГЧ

А.МӨНХТУУЛ

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:
АМЬТАН СУДЛАГЧ

Б.УЧРАХБАЯР